# 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Говьсүмбэр аймаг, Сүмбэр сумын нутагт байрлах
“Гаалийн хяналтын талбай” төсөл

“ДУУТ НУУР ХӨГЖИЛ” ХХК

## АГУУЛГА


ОРШИЛ ....3
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ....4
1.1. Төслийн нэр ....4
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага ....4
1.3. Төслийн байршил ....4
1.4. Төслийн хүчин чадал, техник технологи ....5
1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга ....5
1.4.2. Төслийн техник технологи ....6
1.4.3. Төслийн байрилга байгууламж, дэд бүтцийн шийдлийн мэдээлэл ....6
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ....9
2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл ....9
2.2. Газрын гадарга ....9
2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг ....10
2.4. Гадаргын болон газрын доорх ус ....11
2.5. Хөрсөн бүрхэвч ....11
2.6. Ургамлан нөмрөг ....12
2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил ....13
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ 14
3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд ....14
3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл ....15
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ....17
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....18
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....24
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....25
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....26
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....28
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ....30
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ....33
АРВАН ХОЁР. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ....34
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ ....35

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил ... 4
Зураг 2. Төслийн ерөнхий төлөвлөлт ... 5
Зураг 3. Чингэлэг өргөх болон буулгах төхөөрөмж ... 6
Зураг 4. Гаалийн хяналтын талбайн бүтэц, зохион байгуулалт ... 8
Зураг 5. Агаарын температурын жил, сарын явц ... 9
Зураг 6. Төслийн талбай орчмын геоморфологи ... 10
Зураг 7. Төслийн талбай орчмын геологийн тогтоц ... 10
Зураг 8. Төслийн талбай орчмын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт ... 11
Зураг 9. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч ... 12
Зураг 10. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг ... 13
Зураг 14. Гадаа байрлуулах хогийн савны жишээ ... 29
Зураг 15. Мониторингийн цэгүүдийн байршил ... 30

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд ... 4
Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл ... 14
Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөлөл ... 14
Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл ... 14
Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл ... 15
Хүснэгт 6. Нөлөөллийн үнэлгээний шалгуур ба анхаарвал зохих асуудлууд ... 15
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ... 18
Хүснэгт 8. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ... 24
Хүснэгт 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ... 25
Хүснэгт 10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө ... 26
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ... 28
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил ... 30
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ... 31
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ... 33
Хүснэгт 15. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь ... 34
Хүснэгт 16. БОМТ-ний нийт зардал, мян.төг ... 35

## ОРШИЛ

“Дуут нуур хөгжил” ХХК нь 2021 оны 05 дугаар сарын 28-нд үүсгэн байгуулагдсан. Говьсүмбэр аймгийн засаг даргын 2023 оны 09 сарын 07-ны өдрийн А/211 тоот шийдвэрээр гаалийн хяналтын талбайн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар олгосон газар эзэмшүүлэх зөвшөөрлийн дагуу тус талбайд төмөр зам, авто зам, автомашины зогсоол, чингэлэгт бараа материал буулгах талбай, задгай нүүрс овоолгын талбай, нүүрс хадгалах хэсэг, ажилчдын байр, хамгаалалтын байр, гэрэлтүүлэг, камержуулалт зэрэг гаалийн хяналтын талбайн бүх шаардлагыг хангасан гаалийн хяналтын талбай байгуулахаар төлөвлөсөн.

Энэхүү төслийн зорилго нь Монгол улсын Төмөр замын тээврийн тухай, бусад холбогдох хууль, дүрэм журам, үндэсний стандартыг баримтлан Говь-сүмбэр аймгийн Чойр өртөөнд төмөр зам, автозам хосолсон уул уурхайн эрдэст бүтээгдэхүүн шилжүүлэн ачих ложистикийн төв шинээр байгуулахад оршино.

Төслийн объект байрлах бүс нутгийн ашигт малтмал ялангуяа төмрийн хүдэр, төмрийн баяжмалыг Замын үүд өртөөгөөр дамжуулан экспортлоход өнөөгийн байгаа хүчин чадал хүрэлцээгүй байгаа болно. Иймд хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний хэмжээг өсгөх зорилгоор уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний ачааны ложистикийн төвийг шинээр барихаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2024 онд “Дорнын байгаль” ХХК боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын яамаар баталгаажуулсан.

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн нэр

“Гаалийн хяналтын талбай” төсөл

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Дуут нуур хөгжил” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 000255216
Регистрийн дугаар: 6709672
Хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, 4-75
Утас: 99138170

## 1.3. Төслийн байршил

Төсөл хэрэгжих талбай нь засаг захиргааны хуваарилалтаарГовьсүмбэр аймгийн Сүмбэр сум, 1-р багийн нутаг дэвсгэрт, Аяган 100а хаягт 15.3 га талбайд байрлаж байна.

Төслийн талбай байрлах Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум нь Улаанбаатар хотоос 225 км-ийн зайтай оршино. Төслийн талбайн байршлыг дараах зургаар харууллаа.




**Зураг 1. Төслийн талбайн байршил**

Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд**

| Нэгж талбарын дугаар\талбайн хэмжээ, га | Цэгийн дугаар | Цэгийн солбицол | |
|---|---|---|---|
| | | Өргөрөг | Уртраг |
| | 1 | 5136067.79 | 295446.45 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нүүрс ачиж, буулгах талбай 15.3 га** | 2 | 5135962.62 | 295509.80 |
| | 3 | 5135838.23 | 295584.70 |
| | 4 | 5135895.17 | 295683.16 |
| | 5 | 5135770.48 | 295751.08 |
| | 6 | 5135635.81 | 295526.08 |
| | 7 | 5135623.74 | 295506.26 |
| | 8 | 5135550.98 | 295412.05 |
| | 9 | 5135872.75 | 295137.06 |
| | 10 | 5135943.16 | 295232.17 |
| | 11 | 5135946.32 | 295237.63 |
| | 12 | 5136067.59 | 295446.10 |

## 1.4. Төслийн хүчин чадал, техник технологи

### *1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга*

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутаг Чойр өртөөг түшиглэн байгуулах Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2022 оны А/339 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх уул уурхайн эрдэст бүтээгдэхүүн хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулна.

Уламжлалт задгай тээвэр болон чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийх үйл ажиллагаа эрхэлнэ.



**Зураг 2. Төслийн ерөнхий төлөвлөлт**

*Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал.*

1. Тээвэрлэж ирсэн ачаа бараа, тоног төхөөрөмж болон уул уурхайн эрдэст бүтээгдэхүүнийг стандарт журмын дагуу аюулгүй найдвартай зориулалтын талбайд буулгах

2. Буусан ачаа бараа, тоног төхөөрөмж болон түүхий эдийг найдвартай стандартад нийцсэн талбайд хадгалах
3. Талбай дахь ачааг чингэлэг ачиж буулгах ачигчаар ачиж пүүлүүлэн лацдаж, гаалийн хяналтад бүрдүүлэлт хийн гаргах.

Орон нутгийн ачаа бараа, тоног төхөөрөмж болон уул уурхайн эрдэст бүтээгдэхүүнийг чингэлэгт тээвэрт ачиж шууд эцсийн хэрэглэгчдэд хүргэж өгснөөр олон удаагийн ачиж буулгах явцыг багасгаж, үүнээс үүсэж буй материалын хорогдол, агаарын бохирдол, тоосжилт зэрэг байгаль орчны асуудлуудыг цогцоор нь шийдэх юм.

Чингэлэгт ачиж буулгах дэвшилтэт технологи /KALMAR маркийн өргөх буулгах төхөөрөмж/-ийг нэвтрүүлнэ. Ингэснээр буулгах болон ачих хугацааг багасгаж тээврийн хэрэгслийн сул зогсолтыг бууруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.




**Зураг 3. Чингэлэг өргөх болон буулгах төхөөрөмж**

### *1.4.2. Төслийн техник технологи*

Гаалийн хяналтын нүүрс буулгах талбайд доорх тоног төхөөрөмжийг ашиглана. Үүнд:

- Дугуйт ачигч /ковш/ - 2ш
- Чингэлэг буулгах болон ачих төхөөрөмж /KALMAR/ - 1ш
- Усны тээвэрлэх машин – 1ш
- Суудлын автомашин – 1ш
- Вагон пүү – 1ш
- Авто пүү – 1ш

### *1.4.3. Төслийн байрилга байгууламж, дэд бүтцийн шийдлийн мэдээлэл*

**Гаалийн хяналтын нүүрс буулгах талбайд доорх барилга байгууламжийг байгуулна. Үүнд:**

- Уламжлалт задгай болон чингэлэгтэй түүхий эд хүлээн авах, ачих, буулгах
- талбай
- Оффисын байр
- Орох болон гарах хаалганы шалган нэвтрүүлэх харуулын байр

- Авто пүү болон пүүлэгчийн байр
- Вагон пүү болон пүүлэгчийн байр
- Гаалийн хяналтын талбайн хашаа
- Гэрэлт цамхгууд /тусгай зориулалтын/
- Бохирын цооног
- Ажилчдын амрах байр
- Гал тогоо, угаалгын өрөө, 00-н хэсэг
- Агуулах
- Гараж засварын цех
- Авто зогсоол

Гаалийн хяналтын нүүрс буулгах талбайн ажилчдын байр нь 20-30 хүний багтаамжтай, нэг давхар сэндвичэн барилга байх бөгөөд нийт 9 өрөө, 1 хурлын заал, нэгдсэн 1 гал тогоотой байна. Гаалийн байгууллага, ачаа тээвэр болон гаалийн хяналтын бүсийн ажилчдын аюулгүй байдлыг хангахын тулд бүрэн хяналтын камерын систем болон гэрээт харуул хамгаалалтын албаар хариуцан ажиллах гэрээ байгуулан ажиллана. Мөн интернэт болон харилцаа холбооны асуудлыг уг салбартаа тэргүүлэгч компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан шилэн кабелын систем ашиглан шийдвэрлэхээр тооцож  байна. Гаалийн хяналтын талбай дээр ухаалаг түгжээ, электрон лац, смарт картаас бүрдсэн смарт систем нэвтрүүлнэ.

**Ус хэрэглээний эх үүсвэр:** Унд, ахуйн зориулалтаар ашиглах усны хэрэглээг зөөврийн усаар хангана.

**Цахилгаан хангамжийн эх үүсвэр**: Талбайн гэрэлтүүлэг болон дотоодын хэрэгцээг УБТЗ-ын харьяа цахилгаан дамжуулах агаарын шугамнаас салаалж дэд станц байгуулан хангана.

Чойр 546-р км-н 10кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №40-өөс кабель шугамаар холболт авч цахилгаан эрчим хүчээр хангагдана.

**Дулаан хангамж:** : Дулаан хангамжийн эх үүсвэрийг сонгохдоо бүс нутгийн цаг уурын үзүүлэлт, оффисын барилгын овор хэмжээ, дулаан хэрэглэгчид болон тэдгээрийн үндсэн зориулалт тавигдах шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ. Дулаан хангамжийг цахилгаанаар шийдсэн бойлертой байна.

***Хүний нөөц.*** Хяналтын талбайн ажилчид ажлын байрны онцлогоос хамаарч өдрийн 12 болон 8 цагаар хоногт 1-ээс 3 ээлжээр ажиллаж, 24 цагийн харуул хамгаалалт болон хяналтын камертай байна. Талбайн ажилчдад талбайн менежер, ХАБЭА-ийн ажилтан, Механик инженер, пүүний оператор, диспертчер, дугуйт ачигчийн оператор, чингэлэг өргөх буулгах төхөөрөмжийн оператор, цахилгаанчин болон гагнуурчин байна. Аж ахуйн ажилчдад жолооч/IT инженер, Тогооч, Үйлчлэгч, Харуул нийт 13 хүн байна. Төслийн талбайн удирдлага зохион байгуулалт бүтцийг графикаар үзүүлэв.




**Зураг 4. Гаалийн хяналтын талбайн бүтэц, зохион байгуулалт**

Одоогийн байдлаар хүний нөөцийн хувьд талбайн эрхлэгч, ХАБЭА ажилтан, 2 ковш оператор, талбайн туслах ажилтан гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа эхлээд байна.

# ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл

Гаалийн талбай байгуулахаар төлөвлөж буй талбай нь Монгол орны хамгийн дулаан бүсд багтдаг бөгөөд уур амьсгалын мужлалаар хэт халуун хуурай зунтай, хүйтэн, хуурай өвөлтэй мужид багтана. Цаг агаарын хэмжилтийн дүнгээс үзэхэд зуны улирлын агаарын дундаж температур +20$^{O}$C байх бол өвлийн улирлын дундаж температур -17$^{O}$C орчим бол жилийн дундаж температурын хэмжээ +3$^{O}$C орчимд хэлбэлзэнэ.

Жилд дунджаар 90-100мм орчим хур тунадас унах бөгөөд нийт хур тунадасын 80% зөвхөн дулааны улиралд 4–р сараас 10-р сарын хугацаанд ногдоно. Хур тунадасны ихэнх хувь нь дулааны улиралд унах учир өвлийн улиралд цастай өдрийн 1-3 орчим байх бөгөөд тогтвортой цасан бүрхүүл тогтдоггүй байна. улиралын хөлдөлт гэсэлтийн гүн хөрсний механик бүрэлдэхүүн болон чийгийн агууламжтай уялдаатайгаар 30см хүртэл гүнд хэлбэлзэнэ. Салхитай өдрийн тоо жилд 30-40 орчим байх бөгөөд үүнээс шороон шуургатай өдрийн 40 дээш орчим буюу нийт жилийн турш маш их хүчтэй салхины нөлөөнд орщдог байна.  Уур амьсгалын нөхцөлийн хуурай-чийг багатай, хүчтэй салхины нөлөөнд орщдог шинж нь төслийн талбайн хөрсөн бүрхэвчийг хуурай, элсэн фракц давамгайлсан, органик бодисын нөөц багатай, давсны агууламж өндөр, карбонатын агууламж их зэргээр илэрдэг.




**Зураг 5. Агаарын температурын жил, сарын явц**

## 2.2. Газрын гадарга

Төсөл хэрэгжиж буй талбай орчмын хөрс үүсгэгч эх чулуулаг нь пролювийн элс, элсэнцэр хурдасаас тогтоно. Ийм гаралтай пролювийн хурдас нь Монголын дорнод хэсгийн элэгдэл-хуримтлалын гаралтай ухаа гүвээт тал болон тэгшивтэр талуудад түгээмэл тохиолдоно. Эдгээр хурдас нь элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонатын агууламж өндөртэй, хөрсний үе давхаргуудад элсэн фракцийн агууламж өндөр, нам дор газруудад хүнд шаврансар бүтэцтэй байдаг.




**Зураг 6. Төслийн талбай орчмын геоморфологи**

## 2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг

Төсөл хэрэгжиж буй талбай орчмын хөрс үүсгэгч эх чулуулаг нь пролювийн элс, элсэнцэр хурдасаас тогтоно. Ийм гаралтай пролювийн хурдас нь Монголын дорнод хэсгийн элэгдэл-хуримтлалын гаралтай ухаа гүвээт тал болон тэгшивтэр талуудад түгээмэл тохиолдоно.




**Зураг 7. Төслийн талбай орчмын геологийн тогтоц**

Эдгээр хурдас нь элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонатын агууламж өндөртэй, хөрсний үе давхаргуудад элсэн фракцийн агууламж өндөр, нам дор газруудад хүнд элсэнцэр бүтэцтэй байдаг.

## 2.4. Гадаргын болон газрын доорх ус

Гаалийн хяналтын нүүрс буулгах талбайн орчимд гадаргын усны хэлбэр байхгүй. Ус зүйн сүлжээгээр Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба Гидрогеологийн мужлалтаар улирлын хомс тэжээлтэй районд багтдаг.




**Зураг 8. Төслийн талбай орчмын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт**

## 2.5. Хөрсөн бүрхэвч

1926 онд Оросын эрдэмтэн Б.Б.Полынов, В.И.Ликовский нар / Өргөө- Чойр- Сайн ус- Бага үд / Улаанбаатар- Чойр- Сайншанд- Замын Үүд/ гэсэн маршрутаар анхны хөрсний судалгаа хийхдээ Чойрын ойролцоо Зараа булаг гэдэг газар буудаллаж тэнд хөрсний зүсэлт хийжээ /зүсэлт-425/. Зүсэлтийн координат нь 460361300, ı25 1080, ı м өндөртэй талын элсэн саарал хөрс тархсан байна гэж тодорхойлжээ. Энэ нь одоогийн хөрсний ангилалзүйгээр тал хөндийн элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хүрэн хөрс тархсаныг тэмдэглэжээ. Энд хөрсний өнгөн хэсэгт 0.5-1.0см зузаантай хайрга, элсэн давхарга тархсаныг анх онцлон тэмдэглэж энэ нь хөрсийг угаагдал, хийсэлт, хэт халалтаас хамгаалдаг болохыг анх удаа онцлон тэмдэглэсэн байна. Оросын эрдэмтэн И.П.Герасимов, Е.М.Лавренко нарын Геоморфологийн мужлалтаар бидний судалгаа хийсэн Чойр орчмын нутаг нь Дорнод монголын бэсрэг уулст нутагт хамаарагдаж байна. Энд бэсрэг уулын ихэнх хэсгийг ухаа, гүвээ, толгод , хотос, хөндий , талархаг газар эзлэдэг онцлогтой. 1950 онд А.А.Юнатов Монгол орны бүс бүслүүрийн ангилалаар Хүрэн хөрстэй дундад халхын хээрийн тойрогт. 1954 онд ургамал газарзүйн мужлалтыг ургамлын аймгийн бүрэлдэхүүнээр тодорхойлж гаргахдаа Дундад халхийн хээрийн тойрогт тус тус хамааруулан ангилсан байна




**Зураг 9. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч**

## 2.6. Ургамлан нөмрөг

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших Чойрын богд уулын ургамлуудаас:Энэ орчин хээрийн бүсэд багтаж Монгол Дагуурын тойргийн гадна байх боловч ургаж байгаа ургамлууд нь Монгол Дагуурын тойрогт ургаж байгаа ургамлууд буюу ихэнх нь ховор ховордсон устаж байгаа ургамлуудадын жагсаалтанд ордог байх юм. Үүнээс үзэхэд Монгол дагуурын тойрогийн хил хязгаар асар хумигджээ. Ургамлын зүйл төрөл цагийн аясаар их өөрчлөгдсөөр Чойрын Богдыг хүрээлэн хээрийн бүсийн хэв шинжийг олж. Уул толгод гэдэг буурал цагийн түүх юм даа. Монгол Дагуурын ургамлын тойргийн хилийн гаднах цэгийг Чойрын Богд уулаар авч харьцуулсан судалгаа хийвэл их л сонин түүх гарна даа. Монгол орны (магад ч үгүй дэлхийн ч байж мэднэ) хамгийн урд цэгт байгаа час улаан долоогоно, тавилгана мэтийн ургамал энэ ууланд бий.




**Зураг 10. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг**

## 2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил

Говьсүмбэр аймгийн 2023 оны жилийн эцсийн нийт хүн ам 18 153 болж өмнөх жилийн мөн үеэс 145 хүн буюу 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй. байна. Нийт хүн амын 9 042 хүн буюу 49.8 хувийг эрэгтэйчүүд, 9 106 хүн буюу 50.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр ангилан авч үзвэл 0-18 настай иргэн 7 405, 19-35 настай иргэн 4 650, 36-55 настай иргэн 4 228, 56-аа дээш настай иргэн 1 870 байна. Говьсүмбэр аймгийн бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2023 оны эхний 5 сарын байдлаар 139 эх амаржиж, 140 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 30 буюу 21.6хувиар, төрсөн хүүхдийн тоо 31 буюу 22.3 хувиар өссөн байна.Бүртгүүлсэн гэр бүл 21, цуцалсан гэр бүл 7 бол нас баралт 38 байна. Өмнөх оны үетэй харьцуулахад цуцалсан гэр бүл 1 буюу 16.7 хувиар буурч, бүртгүүлсэн гэр бүл 8 буюу 38.1 хувиар, нас баралт 16 буюу 42.1 хувиар тус тус өссөн бол тайлант хугацаанд 3 хүүхэд үрчлэгдсэн байна.Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 90 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 194 хүнээр буюу 68.3 хувиар буурсан байна.

# ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд

### *3.1.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөлөх нь:*

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн төмөр замын салаа, машин техникийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт, шатах тослох материалын ууршилт, машин механизмын яндангаар хаягдах хорт хий, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр агаарын хими, физикийн бохирдолтод орох зэргээр давхардмал бохирдолтуудад орох магадлалтай. Гэхдээ энэхүү нөлөөлөл нь бага юм.

**Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл**

| Нөлөөллийн хэлбэр | Нөлөөллийн үр дагавар | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Маш бага | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх шаталтын процессоос үүсэх хорт хий | | + | | | |
| Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах өргөгч тоног төхөөрөмжүүд | | | + | | |
| Тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт | | | | + | |

### *3.1.2. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нь:*

Одоогийн байдлаар хөрсний эвдрэл байхгүй бөгөөд харин хөрс нь хүний болон машин техникийн нөлөөгөөр дагтаршиж доройтсон байна. Ачилт буулгалтын талбайн барилга байгууламжийн үед болон нүүрсийг ачих буулгах тээвэрлэлт зэрэг үйл ажиллагааны нөлөөнд тухайн газрын гадарга бага зэрэг өртөж доройтсон байна.

**Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөлөл**

| Нөлөөллийн хэлбэр | Нөлөөллийн үр дагавар | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Маш бага | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| Вагон зам, ачилт буулгалтын талбай, авто зам, автомашины зогсоол, уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний овоолгын талбай, хадгалах хэсэг, ажилчдын байр, хамгаалалтын байр байгуулах | | | + | | |

### *3.1.3. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх нь:*

**Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл**

| Нөлөөллийн хэлбэр | Нөлөөллийн үр дагавар | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Маш бага | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| Ахуйн бохир ус, хатуу хог хаягдал ил задгай хаягдаж алдагдсанаас гадаргын болон газрын доорх ус бохирдох | | | + | | |

### *3.1.4. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нөлөөлөх нь:*

Машин техник, хүний хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

**Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл**

| Нөлөөллийн хэлбэр | Нөлөөллийн үр дагавар | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Маш бага | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| Ургамлан нөмрөгийн талхагдал | | | + | | |
| Ургамлын төрөл зүйлийн хомсдох | | + | | | |

### *3.1.5. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх нь:*

Одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа. Цаашид үйл ажиллагаа явуулахад хашаа барьсан тул ойр хавийн айлын мал нэвтэрч орохгүй болно.

### *3.1.6. Төслийн үйл ажиллагааны нийгэм, эдийн засагт нөлөөлөх нь:*

Төсөл хэрэгжсэнээр ажлын байр тодорхой хэмжээгээр нэмэгдэх давуу талтай. уул уурхайн компаниуд /Оюу толгой, Энержи ресурс, Эрдэнэс таван толгой, Орон нутгийн Таван толгой гэх мэт/ болон Говьсүмбэр аймгийн хүн амын хүнс, бараа материал, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, мөн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний тээвэр ложистикийн төвийг байгуулж авто замаар явах хүнд даацын автомашины хэрэглээг багасгаж, авто тээврийн осол аваар, байгаль орчны бохирдлыг бууруулж, ачаа тээврийн хanган нийлүүлэлтийг баталгаатай, найдвартай, хурдан шуурхай болгон сум орон нутаг болон Монгол улсын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулах зорилгоор төслийн ажлыг эхлүүлээд байна.

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

## 3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс цаашид төсөл хэрэгжих явцад агаарын чанар, хөрсөн бүрхэвчийн бохирдолд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах тал дээр илүү түлхүү анхаарч, хяналт тавин ажиллах бөгөөд төслийн гол сөрөг нөлөөллүүдийг доорх байдлаар нэгтгэн харуулав.

**Хүснэгт 6. Нөлөөллийн үнэлгээний шалгуур ба анхаарвал зохих асуудлууд**

| Байгаль орчин/ нийгмийн асуудлууд | Орон нутгийн хэмжээнд байгаль орчин, нийгэмд үзүүлж буй аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөлөл. Хамгийн их нөлөө үзүүлж байгаа асуудлыг хамгийн ноцтой асуудал гэж тооцно. |
|---|---|
| Байгаль орчин /нийгмийн элемент буюу нөлөөлөлд өртөж болзошгүй параметрүүд | Байгалийн физик шинж чанар: Агаарын чанар, чимээ шуугиан, газрын доорх усны төлөв байдал, чанар, хөрсний чанар, геоморфологи |

| | |
|---|---|
| | Биологийн буюу экологийн нөөц баялаг:Ургамал, амьтан, ургамал амьтан, тусгай хамгаалалттай газар нутаг, дархан цаазтай амьтан ургамлын төрөл зүйл<br>Хүний хэрэглээний үнэ цэнэ: Аж үйлдвэр, зам тээвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн усны хангамж, орон нутаг дахь хаягдал усны менежмент, хатуу хог хаягдлын менежмент, эрчим хүчний хэрэглээ, цахилгаан эрчим хүчний хангамж<br>Амьдралын чанар: нийгмийн үнэ цэнэ, нийгэм-эдийн засаг, боловсрол, археологийн үнэ цэнэ, байгалийн үзэсгэлэн, эрүүл мэнд, аюулгүй байдал |
| Хууль эрх зүйн шаардлага | Тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх арга хэлбэрийг заасан журмуудыг батлан гаргана. |
| Байгаль орчны нөлөөллийн далайц | Бараа материал, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, мөн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний тээвэр ложистикийн төвийг байгуулах учир тоосжилт багасан. |
| Нөлөөлөл үүсэх газар зүйн байрлал | Гаалийн хяналтын талбайн Сүмбэр сумын 1-р багын нутаг дэвсгэр буюу өөрийн эзэмшлийн 15,3 га талбайд явагдана. . |
| Нөлөөлөл үргэлжлэх хугацаа давтамж | Гаалийн хяналтын талбайн барилга байгууламжийн явцад тоног төхөөрөмжөөс дуу чимээ тархана. Тоосжилт болон дуу чимээ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад л тархах үргэлжлэх хугацаа богино юм. Харин цаашид ашиглалтын явцад төмөр замын дуу чимээ нэмэгдэнэ. |
| Хүмүүст нөлөөлөх байдал | Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд тээврийн зам, төмөр зам байгаа хэдий ч, суурьшлын бүс байхгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, дуу чимээ нь талбайд ажиллаж байгаа ажилчдад нөлөөлнө. |
| Нөлөөллийн эрсдэл | Болзошгүй нөлөөлөлд тус үйлдвэрийн хашаалсан талбай болон ажилчид өртөнө. |
| Нийгэм эдийн засгийн хувьд үзүүлэх нөлөө | Говьсүмбэр аймгийн хүн амын хүнс, бараа материал, тоног төхөөрөмжийн хანган нийлүүлэлт, мөн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний тээвэр ложистикийн төвийг байгуулж авто замаар явах хүнд даацын автомашины хэрэглээг багасгаж, авто тээврийн осол аваар, байгаль орчны бохирдлыг бууруулж, ачаа тээврийн ханган нийлүүлэлтийг баталгаатай, найдвартай, хурдан шуурхай болгон сум орон нутаг болон Монгол улсын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулна. |
| Нөхөн сэргээж болох эсэх | Төслийн талбайн 20-оос доошгүй хувьд ногоон байгууламж байгуулах шаардлагатай. |
| Институцийн чадавх | Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нөлөөллийн асуудлаар ажиллах чадавх сул байдаг. БОАЖЯ болон үнэлгээний мэргэшсэн ХХК-уудаас туслалцаа авах шаардлагатай гэж үзэж байна. |
| Байгаль орчин, нийгэм эдийн засгийн үзүүлэлт | Байгаль орчинд дунд зэргийн сөрөг нөлөөтэй, энэ нь богино хугацаанд нөлөөлөл үзүүлнэ. Улс болон орон нутгийн эдийн засагт эерэг нөлөөлөлтэй. |
| Нөлөөллийн нийт үнэлгээ | Нөлөөлөл дунд зэрэг боловч богино хугацаагаар үргэлжлэх эрсдэлтэй. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд сахиж ажиллах шаардлагатай. |

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах “Гаалийн хяналтын талбай” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, заасврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгасан байгаль орчны бүрэдэхүүн хэсэгт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн жил бүр мөрдөн ажилладаг байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь төслийн төгсгөлийн ажлын үе шатанд байгаль орчинд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зардал, хариуцах эзний хамтаар төлөвлөн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад чиглэнэ.

## ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган 2024 онд хэрэгжүүлэх байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

**Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Агаар орчин*** | | | | | | | | |
| 1 | Нүүрс тээвэрлэх, ачих, буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх ажлын үед тоос, тоосжилт үүсэх | Тоосжилт бууруулах 8 м-ээс багагүй өндөртэй зориулалтын хашааг талбайн хойд болон зүүн талыг тойруулан барих, тогтмол засварлаж байх, бүрэн бүтэн байдалд хяналт тавих | Талбайн хойд болон зүүн талд 580 м урт | Үйл ажиллагааны зардлаар | | | 2024 онд тогтмол хянаж байх | - Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ) MNS 4585:2007 (Гадна агаарын ЗДХ) - Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга MNS 5364:2004 |
| 2 | | Зам талбайн усалгааны зориулалтын автомашинтай болох | “Дуут нуур хөгжил” ХХК | Үйл ажиллагааны зардлаар | | | 2024 онд | |
| 3 | | Тоосжилт үүсгэж буй зам талбайн тоосжилтыг дарах усалгаа хийх | Вагон ачилтын 80 м өргөн, 380 м урттай 2 талын талбай /6 га/ болон 4 м өргөн, 800 м тээврийн зам /0.3 га/ | Үйл ажиллагааны зардлаар | | | 2024 онд тогтмол | |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Төслийн ачиж буулгах талбайн хэсгийг хайрган хучилттай болгох, нягтаршуулж, дагтаршуулж талбай бэлдэх | 9,000 м3 ухмал болон дуургэлтийн материалаар 12 м өргөн тэгш дайрган хучилттай талбай, 0-1 см 4 градус бүхий налуутай талбайг нягтруулах /40м x 40м талбай/ | Гэрээт ажлын үнийн дүнгээр үйл ажиллагааны зардал /250,000,000 төгрөг/ | | | 2024 онд | |
| 5 | | Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох 5 км/цаг (шороон замд 20-40 км/цаг-с хэтрүүлэхгүй) шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлэх; | Эзэмшил талбайн дундах зам, нүүрс ачих буулгах талбай | Үйл ажиллагааны зардал | | | 2024 онд | |
| 6 | Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс хорт хий ялгарах | Тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх; | Үйл ажиллагаанд ашигладаг тээврийн хэрэгслүүд | Дотоод төлөвлөлтөөр хийгдэнэ | | | 2024 онд | MNS 5013:2009/MNS 5014:2009 “Дизель болон бензин хөдөлгүүртэй автомашин– утааны тортогжилтын ЗДХ ба хэмжих арга” |
| 7 | Ахуйн хог хаягдлаар Агаар бохирдох | Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй | Хаягдлын цэгийн орчимд | Хог хаягдлын менежментийн Төлөвлөгөөнд тусгасаны дагуу | | | 2024 онд | - Хог хаягдлын тухай хууль, 2017 он |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Too, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах | | | | | | - Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011 |
| ***Газрын гадарга, хөрсөн бүрхэвч*** | | | | | | | | |
| 8 | Хог хаягдлаар газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдох | Хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийх | Төслийн хаягдлын цэгийн орчимд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу | | | 2024 онд | - Хог хаягдлын тухай хууль, 2017 он<br>- Хаягдлын цэгийн стандарт MNS BS 5906:2015<br>- Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011 |
| 9 | | Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсэх шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хаягдлыг дахиварын үйлдвэрт тушаах, боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах | | | | | | |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Бохирын цооногоор дамжин хөрс бохирдох | Холбогдох журмын дагуу бохирын цооногийн септик системийн тохижуулалтыг хийх | Төслийн шингэн хаягдлын цэгийн орчимд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу | | | 2024 он | - Хог хаягдлын тухай хууль, 2017 он<br>- Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам. |
| 11 | | ахуйн бохир усны септик системийн байнгын бүрэн бүтэн байдал, үйл ажиллагаанд анхаарч ажиллах, | | | | | | |
| 12 | Талбайн газрын гадарга, хөрс элэгдэл эвдрэлд өртөх | Автомашины зам, зогсоолыг дагтаршуулах, усалж байх | Эзэмшил талбайд | Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу | | | 2024 онд | - “Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342 : 2007<br>- “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 |
| 13 | | Ногоон байгууламж байгуулах | | | | | | |
| 14 | Тос тосолгооны Материалын хаягдлаар хөрс бохирдох | Шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн авах, бохирдсон хөрсийг хусаж авах, саармагжуулах арга хэмжээ авах | Автомашины зогсоол, нүүрс ачих буулгах талбайн орчинд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу | | | 2024 онд үйл ажиллагааны туршид | - Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991<br>- Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элемемнтүүдийн |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008. |
| 15 | Машины сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлаар хөрс бохирдох | Сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлыг тусгаарласан хашлага бүхий тусгай талбайд хуримтлуулах | Хаягдлын цэгийн орчимд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу | | | 2024 оны 2-р улиралд | - Хог хаягдлын тухай хууль, 2017 он<br>- Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, |
| ***Ургамлан нөмрөг*** | | | | | | | | |
| 16 | Ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөх | Мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх | Төслийн талбайд | Ногоон байгууламж байгуулах зардалд тусгах | | | 2024 онд | “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 |
| 17 | Хүн болон машин механизмуудын замбараагүй хөдөлгөөнөөс болоод ургамлан нөмрөг доройтох | Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох төслийн талбайд явган хүний болон машин техникийн хөдөлгөөний зам, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлэх, даган мөрдөх | Төслийн талбай | “Дуут нуур хөгжил” ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд орно | | | 2024 онд өдөр бүр | |
| ***Усан орчин*** | | | | | | | | |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | Төслийн талбай, барилгын эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдах, гүний усанд бохирдол үүсэх | Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх | Унд, ахуйн хэрэглээний усан хангамж | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан | | | 2024 онд улиралд 1 удаа | MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ |

## ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд ачилт буулгалтын талбайд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

**Хүснэгт 8. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Нийт зардал /төг/ | Хариуцах эзэн | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Ургамлан бүрхэвч, орчны тохижилт* | | | | | | | |
| 1 | Нүүрс тээвэрлэлт, ачилт буулгалтын улмаас ургамлан нөмрөг устан, орчны ургамлан бүрхэвч доройтох | Ногоон байгууламж бий болгох, тордож байх | Төслийн талбайд 50 ширхэг мод тарих | 5000 | 50ш *5000=250,000 | “Дуут нуур хөгжил” ХХК | |
| 2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих | 50 ширхэг | 5000 | 250,000 төгрөг | | Нутгийн иргэнтэй хамтран ажиллах /арчилгаа, усалгаа хариуцахгүй тохиолдолд төслийн талбай руу шилжүүлэн тарьна/ | |
| 3 | Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын хэвлий бохирдох | Цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх | Гаалийн хяналтын талбайн гадна, дотор талбайд | Үйл ажиллагааны хүрээнд | | “Дуут нуур хөгжил” ХХК | Бүх нийтийн цэвэрлэгээ хийх |
| **Нийт зардал** /Энд зөвхөн модны үрсэлгээ худалдан авалтын зардал багтсан бөгөөд арчилгаа, усалгааны зардал ороогүй болно/ | | | | | | **500,000 төг** | |

## ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Гаалийн хяналтын талбай болон түүний орчимд одоогоор түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй бөгөөд хэрвээ тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай Сүмбэр сумын, засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах болно.

**Хүснэгт 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|
| **1** | Археологийн дурсгал, олдвор | Төслийн барилга байгууламжийн ажлын үед соёлын биет өв илэрвэл төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож, Энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад мэдэгдэх. | “Дуут нуур хөгжил” ХХК-ийн ачилт буулгалтын хяналтын талбай | 2024 онд соёлын биет өв илэрсэн тохиолдолд | Соёлын өвийн тухай хуулийн 38.3 |
| **2** | Палеонтологийн дурсгал, олдвор | | | | |

## НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Гаалийн хяналтын талбай" төслийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэн гардаг. Энэ нь машин техник, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйл ажиллагааны хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

**Хүснэгт 10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө**

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга Хэмжээний цар, хэмжээ | Нийт зардал сая. төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|
| ***Байгалийн гаралтай осол эрсдэл*** | | | | | |
| Байгалийн гамшгийн улмаас ажилчдын эрүүл мэнд, техник тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарч болзошгүй | Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай бороо орох үед үйл ажиллагааг түр зогсоох | Төсөл хэрэгжих бүс | Үйл ажиллагааны зардал | 2024 он | Гамшгаас хамгаалах тухай хууль |
| | Гэнэтийн осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт зохион байгуулах | Ачилт буулгалтын талбай | | 2024 он | |
